

АРД КРЕДИТ ББСБ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хурлын огноо: 2026 оны 4 сарын 27-ны өдөр;

Хурлын байршил: Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сүхбаатарын талбай 2, Сэнтрал тауэр барилгын 17 давхарт “Ард Санхүүгийн нэгдэл” ХК-ийн байр

Хурал эхэлсэн цаг: 11:00 цаг;

Хурлын дарга: Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (Цаашид “ТУЗ”гэх)-ийн дарга Ч.Ганзориг;

Хуралд оролцсон удирдлагын багийн гишүүн: ТУЗ-ийн Хараат бус гишүүн Б.Солонго, Гүйцэтгэх захирал Г.Сүхбаатар,

Хуралд урилгаар оролцсон Хараат бус аудитын байгууллагын төлөөлөл: Нексия Глобал Монголиа аудит ХХК-ийн партнер, гүйцэтгэх захирал Э.Булган

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. Компанийн 2025 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
3. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
4. Ногдол ашиг хуваарилах талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийг танилцуулах;
5. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох;
6. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсвийг батлах;
7. Ард Кредит ББСБ ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
8. Компанийн тамга шинэчлэх;

Хурлын ирцийн танилцуулга: Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл

Ард кредит ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 1 тогтоолыг танилцуулъя.

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх заалт хэсэг, Ард Кредит ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компани нийт гаргасан 364,000,000 ширхэг энгийн хувьцаатай байна. Үүнээс саналын эрхтэй 360,777,434 ширхэг энгийн хувьцаанаас 294,516,902 ширхэг буюу 81.63 хувийг эзэмшиж байгаа Хувьцаа эзэмшигчид хуралд оролцогчдод болон хурлын даргад мэдэгдсүгэй.

2. Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт болно.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН САНАЛ: Хурлын ирцтэй холбогдуулан Хувьцаа эзэмшигчдээс санал гаргаагүй болно.

ХЭХ-ийн нээлт, хурлын дэг танилцуулах: Хурлын дарга Ч.Ганзориг



“Ард Кредит ББСБ” ХК нь Ард санхүүгийн нэгдлийн томоохон компаниудын нэг энэ жил компанийн маань 15 жилийн ой тохиож байна. Өдгөө компани маань 14,200 гаруй хувьцаа эзэмшигчтэй болж, нийт активын хэмжээ 116 тэрбум болсон байна. Энэ жилийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас хэлэлцэх асуудлууд өмнөх жилийнхээс өргөн хүрээтэй байгаа тул хэлэлцэх асуудлуудаа хэлэлцээд илүү их цагийг хувьцаа эзэмшигчдийнхээ санал бодлыг сонсож асуулт, хариултад хариулъя. Ингээд хурлын дэгийг та бүхэнд танилцуулъя. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг компанийн гүйцэтгэх захирал Г.Сүхбаатар, 2025 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг Нексия Глобал Монголиа аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Булган танилцуулах, 2025 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг, Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг Хараат бус гишүүн Б.Солонго танилцуулж хэлэлцүүлэх, Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулах, Ногдол ашиг хуваарилах эсэх тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэр, ТУЗ-ийн 2026 оны төсвийг ТУЗ-ийн дарга миний бие, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах өөрчлөлт, компанийн тамга шинэчлэх асуудлыг гүйцэтгэх захирал Г.Сүхбаатар нар тус тус танилцуулна.

Өнөөдрийн хуралд компанийн удирдлагын баг, ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч нар бүрэн бүрэлдэхүүнээрээ ирсэн байгаа. Хувьцаа эзэмшигч та бүхэн хурлын үеэр асуулт асууж, саналаа хэлэх боломжтой гэдгийг хэлье. Өнөөдрийн хурлаас ТУЗ-ийн дүгнэлтийг батлах, ТУЗ-ийг гишүүдийг сонгох, ТУЗ-ийн төсвийг батлах, Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, компанийн тамгыг шинэчлэн солиулах гэсэн 5 шийдвэр гаргахаар байгаа. Хувьцаа эзэмшигч та бүхэн саналаа аппаар болон цаасаар өгөх боломжтой. Санал хураалтын дүнг нэгтгээд, тогтоолын төслүүдээ та бүхэндээ танилцуулаад батлуулаад хурлаа хаана. Та бүхэнд дэгтэй холбоотой санал байна уу?

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН САНАЛ: Хурлын дэгт холбогдуулан Хувьцаа эзэмшигчдээс санал гаргаагүй болно.

Хурлын дарга Ч.Ганзориг: Хурлын дэгт санал гараагүй тул Хувьцаа эзэмшигчдийн хуралд нь амжилт хүсье. Хэлэлцэх асуудлын дагуу Гүйцэтгэх захирал Г.Сүхбаатарыг танилцуулгаа хийхийг урьж байна.


1. Компанийн 2025 оны үйл ажиллагаа санхүүгийн тайлангийн танилцуулга:

Танилцуулга хийсэн Гүйцэтгэх захирал Г.Сүхбаатар

Үйл ажиллагааны танилцуулга:

Ард Кредит ББСБ нь байгуулагдаад 15 жилийг өнгөрөөсөн байна. Энэ хугацаанд компанийн стратеги маань финтекэд суурилсан нээлттэй компанийн засаглалтай байхыг төлөвлөж, дэд бүтэц үндсэн систем, үйл ажиллагаа явуулах зөвшөөрлөө зохицуулагч байгууллагаас авч та бүхний ашиглаж Ард апп 2018 онд бий болгож, энэ хугацаанд 5 хувилбарыг гаргаж, Ард Аппыг тасралгүй сайжруулж, олон олон нэмэлт боломжуудыг нэвтрүүлснийг товч дурдвал Ард Аппад харилцагчийн сегментчлэлийг нэвтрүүлж, харилцагч бүтээгдэхүүн үйлчилгээнүүдийг хамгийн таатай нөхцөлөөр авах боломжтой боллоо. хийх боломжтой боллоо.

2019 онд анх олон нийтэд хувьцаагаа санал болгон гаргаж нээлттэй компани болж, 2024 онд нэмж хувьцаагаа олон нийтэд нээлттэй гаргаж 8.9 тэрбумын хөрөнгийг босгосон байна. Ард Апп нь харилцагчдад хамгийн таатай нөхцөл бүхий финтек зээл олгох боломжийг бүрдүүлж Ард Аппын хэрэглээнд тулгуурласан лоялти скоринг, СайнСкор ХХК-тай хамтран FICO онооны системийг онлайн зээлийн скорингд нэвтрүүлэв. Ард Аппаар зээлийн гэрээ байгуулах боломжтой болсноор Монгол улсын хаанаас ч, тэр ч байтугай гадаад улсад байхдаа хүртэл зээл авах боломжтой болов. Харилцагч хүссэн дүн, хугацаагаар хуримтлал үүсгэх боломжтой зорилтот хуримтлалын үйлчилгээг нэвтрүүллээ. 2023 онд Банк бус санхүүгийн байгууллагын салбарт анхны карт гаргагчийн тусгай зөвшөөрөл бүхий Элит болон Премиум зэрэглэлийн Кредит картыг Ардын харилцагчдадаа зориулан гаргасан. 2017 онд мөн л салбартаа анхлан ко-брэнд кредит картыг хэрэглээнд нэвтрүүлж байсан билээ. 2024 онд Банк бус санхүүгийн



байгууллагын салбар салбарын анхны төгрөгийн дебит картыг хэрэглээнд нэвтрүүлж, Ард дебит картын гүйлгээ бүрд урамшуулал олгон ажиллаж байна. Ард Аппад бусад банкны картаа холбон төлбөр тооцоо

Ард Кредит ББСБ ХК-ийн хувьд 2025 он дотоодын зах зээл дэх байр сууриа бэхжүүлээд зогсохгүй, олон улсын тавцанд хүлээн зөвшөөрөгдөж, санхүүгийн засаглалын шинэ түвшинд гарсан түүхэн жил байлаа. Бид дэлхийн санхүүгийн төвүүдтэй харилцаа холбоогоо идэвхжүүлж, дараах томоохон ажлуудыг амжилттай хэрэгжүүлээ:

- Crowd Credit (Япон): 10-р сарын 7-нд Японы Крауд Кредит сангаас транч татан авч, Япон улсад амжилттай уулзалт хийв.
- Сингапурын түншлэл: Lendable, Helicap, болон Surfin компаниудтай стратегийн хамтын ажиллагааны (NDA) гэрээнүүд байгуулж, бүс нутгийн санхүүжилтийн сувгуудыг нээлээ.
- Стандарт ба Хүлээн зөвшөөрөлт: Мэдээллийн аюулгүй байдлын ISO 27001:2022 сертификатаа 3 дахь жилдээ амжилттай шинэчилж, IDCXS:2022 дижитал үйлчилгээний стандартыг нэвтрүүлэв. Мөн Хятадын "Maker in China" уралдаанаас Black Horse Award хүртсэн нь бидний технологийн дэвшлийг батлан харууллаа.
- Дотоодын хүртээмж: Монгол Шуудан ХК-тай хамтран ПОС төхөөрөмжөөр дамжуулан орон нутагт санхүүгийн үйлчилгээг ойртуулахаар болсон нь нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлсэн чухал алхам байв.

Эдгээр стратегийн арга хэмжээ болон гадаад санхүүжилтийн үр дүнд компанийн нийт хөрөнгө өмнөх оноос 1.1 хувиар өсөж 116.7 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд зээлийн багц маань 25.8 хувиар тэлж, 94.1 тэрбум төгрөгт хүрсэн байна. Үүнтэй зэрэгцэн компанийн үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдэж, нийт орлого өмнөх оноос 41.7 хувиар өсөж 33 тэрбум төгрөгт хүрсэн бол цэвэр ашгийн хувьд 3.5 тэрбум төгрөгт хүрч, хуримтлагдсан ашгийн хэмжээг 35 хувиар буюу 16.8 тэрбум төгрөг хүртэл өсгөж чадсан амжилтын жил боллоо.

Мөн тус онд Ард Кредит компанийн нэгж хувьцааны ханш зах зээлийн савлагааг амжилттай давж, жилийн эцэст 114.18 төгрөгт хүрсэн бол Монголын хөрөнгийн бирж дээр нийт 1.1 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь хөрөнгө оруулагчдын итгэл тогтвортой байгааг харууллаа. Энэхүү идэвхжил нь компанийн зах зээлийн үнэлгээг 41.6 тэрбум төгрөгт хүргэж, санхүүгийн чухал үзүүлэлт болох хөрвөх чадварын харьцааг 17.3 хувьд (зохистой харьцаа мин 8%) барьж чадлаа.

Ард Кредит компанийн нэгж хувьцааны ханш зах зээлийн савлагааг амжилттай давж, жилийн эцэст 114.18 төгрөгт хүрсэн бол Монголын хөрөнгийн бирж дээр нийт 1.1 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь хөрөнгө оруулагчдын итгэл тогтвортой байгааг харууллаа. Энэхүү идэвхжил нь компанийн зах зээлийн үнэлгээг 41.6 тэрбум төгрөгт хүргэсэн юм.

Бид нээлттэй компанийн хувьд зохицуулагч байгууллагаас баталсан засаглалын бодлого буюу кодексийг хэрэгжүүлэх хүрээнд өнөөдөр хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй нээлттэй компаниудын засаглалын кодексийг хэрэгжүүлэгч топ-10 компанийн нэг болсон, энэ нь ганцхан жилийн үр дүн биш, олон жилийн зорьж ажилласны үр дүнг зохицуулагч байгууллагаас бидэнд өгсөн үнэлгээ гэж хардаг. Компанийн засаглалын хувьд Нээлттэй ХК болсноос хойш хувьцаа эзэмшигчдийнхээ итгэлийг алдалгүй Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 индекс, I ангилалд тасралтгүй багтаж амжилтаа бататгалаа. Монголын банк бус Санхүүгийн байгууллагаас 2025 оны шилдэг Санхүүгийн хүртээмжтэй банк бус Санхүүгийн байгууллагаар шалгарлаа.



2. Компанийн 2025 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулга

Танилцуулга хийсэн: Нексиа Глобал Монголиа аудит ХХК-ийн партнер, гүйцэтгэх захирал Э.Булган

Ард Кредит ББСБ ХК нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн дэлгэрэнгүй орлого, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайлангууддаа хараат бус аудитын шалгалтыг амжилттай хийлгэж гүйцэтгэлээ. Энэхүү аудитын шалгалтаар компанийн нийт хөрөнгийн хэмжээ 116,752 сая төгрөгт хүрч, нийт өр төлбөр 76,308 сая төгрөг, харин нийт өөрийн хөрөнгө 40,444 сая төгрөгөөр тус тус баталгаажсан байна. Тайлант хугацаанд нийт хүү болон түүнтэй адилтгах орлогоос 21,679 сая төгрөгийг төвлөрүүлж, хүүгийн зардалд 12,826 сая төгрөг зарцуулснаар татварын өмнөх ашгийн хэмжээ 4,076 сая төгрөгт хүрсэн үзүүлэлттэй гарчээ. Аудитын дүгнэлтээр дээрх санхүүгийн тайлангууд нь компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт буюу СТОУС-ын дагуу үнэн зөв, бодитой толилуулсан болохыг албан ёсоор баталгаажуулалаа.

3. 2025 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах

Танилцуулга хийсэн: ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Солонго

Тайлант хугацаанд ТУЗ-ийн дэргэдэх хороод тогтмол хуралдаж, бүрэн эрхийн хүрээнд ээлжит хурал 4 удаа, ээлжит бус хурал 1 удаа хуралдаж, эчнээ санал хураалт 46 удаа явуулан нийт 63 тогтоол баталж, нээлттэй компаниас олон нийтэд мэдээлэл хүргэх тухай журамд заасны дагуу Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр олон нийтэд мэдээлж ажиллав.

ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа

Ард Кредит ББСБ ХК-ийн ТУЗ нь эрх үүргээ бүрэн хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах зорилгын хүрээнд Санхүү, эрсдэл, зээлийн хороо, Засаглал, нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Дотоод аудитын хороодтойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Санхүү, эрсдэл, зээлийн хороо

ТУЗ-ийн дэргэдэх Санхүү, эрсдэл, зээлийн хороо нь компанийн санхүүгийн тогтвортой байдал, зээлийн бодлого, эрсдэлийн удирдлагын стратегийг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэлээ.

Тус хороо нь компанийн стратеги төлөвлөгөөг судалгаанд суурилан боловсруулж ТУЗ-д танилцуулан батлуулах, компанийн үнэлгээ болон хувьцааны үнэ цэнийг хамгаалах, нэмэгдүүлэх бодлогын санал боловсруулах, зээл олголт болон багцын чанарт хяналт тавих, зээлийн саналуудыг бүрэн эрхийн хүрээнд хэлэлцэн шийдвэрлэх чиглэлээр ажиллалаа.

2025 онд тус хороо ээлжит 4 удаа, ээлжит бус 1 удаа, эчнээ санал хураалт 10 удаа зохион байгуулж, компанийн зээлийн бодлого, эрсдэлийн удирдлагын хүрээнд шаардлагатай шийдвэрүүдийг тухай бүр гаргасан байна.

Хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн О.Одбаяр, гишүүдээр Б.Золбоо, Г.Сүхбаатар нар ажиллаж байна.

Аудитын хороо

Аудитын хороо нь санхүү, бүртгэлийн үйл ажиллагаа нь батлагдсан төсөв, төлөвлөгөө болон олон улсын стандартын шаардлагад нийцэж буй эсэхэд хараат бус дүгнэлт өгөх, дотоод аудит, дотоод хяналтын тогтолцооны үр нөлөөнд хяналт тавих, хөндлөнгийн аудиторыг сонгон шалгаруулах, аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиг үүргийг хэрэгжүүлэв.

Тайлант онд тус хороо ээлжит 4 удаа, ээлжит бус 1 удаа зохион байгуулж, санхүүгийн тайлагнал, дотоод хяналтын тогтолцооны үр ашигт байдалд хяналт тавин ажиллаж байна.



Хорооны даргаар хараат бус гишүүн В.Ганзориг, гишүүдээр С.Энхчимэг, М.Мөнх-Эрдэнэ нар ажиллаж байна.

Засаглал, нэр дэвшүүлэх хороо

Засаглал, нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга болон гүйцэтгэх удирдлагыг нэр дэвшүүлэх, тэдгээрийг үнэлэх шалгуур, журмыг боловсруулж хэрэгжүүлэх, ТУЗ-ийн гишүүдийн оролцоо, идэвх, хараат бус гишүүдийн хараат бус байдлыг үнэлэх, залгамж халааны бодлогыг боловсруулж ТУЗ-өөр батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүллээ.

2025 онд тус хороо ээлжит хурал 3 удаа, ээлжит бус 1 удаа, эчнээ санал хураалт 2 удаагийн явуулж, засаглалын бодлого, хүний нөөцийн залгамж халааны төлөвлөлтийн асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв.

Хорооны даргаар хараат бус гишүүн Б.Солонго, гишүүдээр Г.Уянга, Б.Золбоо нар ажиллаж байна.

Цалин урамшууллын хороо

Цалин, урамшууллын хороо нь гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтнуудын цалин, урамшууллын бодлогыг компанийн гүйцэтгэл, стратегийн зорилттой уялдуулан боловсруулах, үнэлэх, ТУЗ-д санал оруулах чиг үүргийг хэрэгжүүлэв.

2025 онд тус хороо 1 удаагийн ээлжит хурал, 2 удаагийн цахим санал хураалт зохион байгуулж, гүйцэтгэх удирдлагын гүйцэтгэлийн үнэлгээ болон урамшууллын бодлогын хэрэгжилтийг хэлэлцэв.

Хорооны даргаар хараат бус гишүүн С.Энхчимэг, гишүүдээр Ч.Ганзориг, Б.Солонго нар ажиллаж байна.

ТУЗ-ийн оцлох шийдвэрүүд:

1. Хөх тэнгэр төсөлд хөрөнгө оруулалт хийж, Блю скай тауэр, 9 давхарыг худалдан авахаар шийдвэрлэв.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулж, компанийн засаглалыг сайжруулах хүрээнд ТУЗ дэргэдэх 4 хороод байгуулах, ТУЗ-ийн төсвийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэхээр хэлэлцэх асуудлыг тусгасан.
3. **Дараах журмуудыг шинэчлэн батлав. Үүнд:**
 - Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Үйл ажиллагааны журам,
 - Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Засаглал, Нэр дэвшүүлэх хорооны журам,
 - Удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны журам,
 - Залгамж халааны бодлого,
 - захирлын үйл ажиллагааны заавар,
4. “Ард кредит ББСБ” ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагаар Нексия Глобал Монголиа аудит ХХК-ийг сонгов.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН САНАЛ: Хувьцаа эзэмшигчид ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбогдуулан санал, зөвлөмж гаргаагүй болно.

4. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн дүгнэлт:

Танилцуулга хийсэн: ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Солонго

Компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон, компанийн санхүүгийн тайланд холбогдох хууль тогтоомжийн дагуу хөндлөнгийн аудит хийж, гаргасан “Нексия Глобал Монголиа Аудит” ХХК дүгнэлтийг хүлээн зөвшөөрөв.

Компанийн 2025 оны Үйл ажиллагааны болон Санхүүгийн тайланг “Хангалттай” гэж дүгнэлээ.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН САНАЛ: Хувьцаа эзэмшигчид ТУЗ-ийн дүгнэлттэй холбогдуулан санал гаргаагүй болно.

5. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэр:

Танилцуулга хийсэн: Хурлын дарга, ТУЗ-ийн дарга Ч.Ганзориг



Ард Кредит ББСБ ХК нь нээлттэй хувьцаат компани болсноосоо хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд нийт дөрвөн удаа 5,200,000,000 төгрөгтэй тэнцэхүйц хэмжээний ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ тараасан. Энэ жилийн тухайд Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 2026/5 тоот тогтоолоор ногдол ашиг хуваарилахаар албан ёсоор шийдвэрлэсэн юм. Уг шийдвэрийн дагуу компанийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгийн 25 хувь буюу 1,106,560,000 төгрөгийг нэгж хувьцаанд 3.04 төгрөгөөр тооцон мөнгөн хэлбэрээр олгохоор боллоо. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр буюу 2026 оны 4 дүгээр сарын 7-ны өдрөөр тасалбар болгон тогтоосон бөгөөд уг ашгийг 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар төлөвлөн ажиллаж байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН САНАЛ: Хувьцаа эзэмшигчид Ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн шийдвэртэй холбогдуулан санал гаргаагүй болно.

6. ТУЗ-ийн гишүүдийг сонгох

Компанийн дүрмийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг гурван жилийн хугацаатай сонгодог бөгөөд энэ жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын өдрөөр гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж байгаа тул шинэ бүрэлдэхүүнийг сонгох шаардлагатай болж байна. Байгууллагын засаглалыг сайжруулах зорилгоор хараат бус гишүүдийн нээлттэй сонгон шалгаруулалтыг 2026 оны 3 дугаар сарын 13-наас 23-ны өдрийн хооронд зохион байгууллаа. Төлөөлөн удирдах зөвлөлийн зургаан ердийн гишүүний тав нь өмнө нь ажиллаж байсан, бүрэн эрхийнхээ хугацаанд идэвх зүтгэлтэй ажилласан гишүүд тул тэднийг дахин нэр дэвшүүлж байгаа юм. Харин шинээр нэр дэвшиж буй Х.Билгүүн нь Ард Кредит ББСБ ХК-ийн санхүү эрхэлсэн захирлаар ажиллаж байсан туршлагатай бөгөөд одоо Ард Секюритиз ҮЦК ХХК-ийн гүйцэтгэх захирлын албыг хашиж байна. Тэрээр олон улсын эдийн засаг, санхүүгийн урьдчилсан таамаглал болон хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн, банк, санхүүгийн салбарт 13 жил ажилласан туршлагатай мэргэжилтэн юм.

Хараат бус гишүүдийн хувьд нийт дөрвөн нэр дэвшигчээс хувьцаа эзэмшигчид гурвыг нь сонгох бөгөөд үүнд 2019 оноос хойш ажиллаж буй В.Ганзориг, 2021 оноос ажиллаж буй Б.Солонго, 2023 онд сонгогдсон С.Энхчимэг нар багтаж байна. Мөн нээлттэй сонгон шалгаруулалтад тэнцсэн шинэ нэр дэвшигч Т.Булган нь банкны эдийн засагч, нягтлан бодогч мэргэжилтэй бөгөөд банк болон комплаенсын салбарт 15 жил ажилласан туршлагатай байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох санал хураалт кумулятив аргаар явагдах тул хувьцаа эзэмшигчид та бүхэн өөрийн эзэмшиж буй хувьцааны тоог 9 үржүүлсэн хэмжээний саналын эрхтэй бөгөөд тус саналын эрхээ бүгдийг нь хувааж, эсхүл тодорхой гишүүдэд хуваан санал өгөх боломжтой юм.

7. ТУЗ-ийн 2026 оны төсвийг танилцуулах

2026 оны төсөвт үндсэн цалинд 123,780,000 төгрөг, урамшуулалд 55,890,000 төгрөг, сургалтын зардалд 13,500,000 төгрөг байхаар тусгаснаар нийт төсвийн хэмжээ 193,170,000 төгрөг болж байгаа юм. Энэхүү төсвийг боловсруулахдаа ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооноос хөрөнгийн бирж дээрх ижил төстэй нээлттэй компаниудын жишиг төсвийг нарийвчлан судалж, холбогдох зөвлөмжийг гаргасан бөгөөд уг зөвлөмжийн дагуу ТУЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн хувьцаа эзэмшигчдийн хуралдаанд танилцуулахаар бэлтгэлээ. Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс цалин, урамшууллын хэмжээг нэмэгдүүлэлгүйгээр сүүлийн 3-4 жилийн турш энэхүү тогтсон төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж ирсэн билээ.

8. Ард Кредит ББСБ ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулга

Танилцуулга хийсэн: Гүйцэтгэх захирал Г.Сүхбаатар

2025 оны эцэст бид компанийн брэнд өнгө, төрх шинэчлэгдэж лого өөрчлөгдсөнтэй холбогдуулан



Компанийн дүрмийн 1.4 дэх заалтад “Компани нь Хүчтэй.Хамтдаа. гэсэн уриа үгтэй байх бөгөөд компанийн бэлгэдэл тэмдэг нь **Ard** Кредит ББСБ байх ба АРД гэсэн үсгээс бүрдсэн байх ба хажууд нь Кредит ББСБ гэж бичсэн байна.” гэж өөрчлөлт оруулахаар та бүхэнд танилцуулж байна.

Мөн лого өөрчлөгдөж байгаа тул компанийн тамгыг дахин шинэчлэх шаардлага үүссэн байгаа юм. Та бүхэнд тодруулах зүйлс байна уу.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН САНАЛ: Дүрмийн шинэчилсэн найруулгын төслийн өөрчлөлтийн саналыг бүхэлд нь зөвшөөрсөн,саналгүй болно.

9. Хэлэлцэх асуудалтай холбоотой, асуулт хариулт

Хувьцаа эзэмшигчдийн тавьсан асуултад Хурлын дарга Ч.Ганзориг болон бусад албан тушаалтнууд зохих хариуг өгсөн болно.Санал гараагүй болно.

10. Саналын хураалтын дүнг нэгтгэх, танилцуулах

Тооллогын комиссын тогтоол танилцуулсан: Ө.Бямбагэрэл

Ард кредит ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 2 тогтоолыг танилцуулъя.

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт хэсэгт заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон болон урьдчилан ирүүлсэн саналыг тоолж, санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2025 оны Үйл ажиллагааны болон Санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай санал хураалтад 294,516,902 ширхэг буюу 81.63 хувийг эзэмшиж байгаа хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

1.1. Зөвшөөрсөн. 294,427,000 ширхэг 99.9%

1.2. Татгалзсан 7,695 ширхэг буюу 0.003%,

1.3. Түдгэлзсэн байхгүй тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар хүчинтэй.

Ард кредит ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 3 тогтоолыг танилцуулъя.

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт хэсэгт заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон болон урьдчилан ирүүлсэн саналыг тоолж, санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж, батлах тухай санал хураалтад 294,516,902 ширхэг буюу 81.63 хувийг эзэмшиж байгаа хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

1.1. Зөвшөөрсөн. 294,431,172 ширхэг 99.97%

1.2. Татгалзсан 7,860 ширхэг 0.003%,

1.3. Түдгэлзсэн байхгүй тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.7 дахь хэсэгт зааснаар хүчинтэй..

Ард кредит ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 4 тогтоолыг танилцуулъя.

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь заалт хэсэгт заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон болон урьдчилан ирүүлсэн саналыг тоолж, санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн тамга шинэчлэх тухай санал хураалтад 294,516,902 ширхэг буюу 81.63 хувийг эзэмшиж байгаа хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

1.1. Зөвшөөрсөн. 294,430,074 ширхэг 99.97%

1.2. Татгалзсан 6,000 ширхэг 0.002%,



1.3. Түдгэлзсэн байхгүй тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.7 дахь хэсэгт зааснаар хүчинтэй.

Ард кредит ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 5 тогтоолыг танилцуулъя.

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь заалт хэсэгт заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон болон урьдчилан ирүүлсэн саналыг тоолж, санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны төсөв батлах тухай санал хураалтад 294,516,902 ширхэг буюу 81.63 хувийг эзэмшиж байгаа хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

1.1. Зөвшөөрсөн. 294,404,936 ширхэг 99.96%

1.2. Татгалзсан 32,890 ширхэг 0.01%,

1.3. Түдгэлзсэн байхгүй тул Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.7 дахь хэсэгт зааснаар хүчинтэй.

Ард кредит ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 6 тогтоолыг танилцуулъя.

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь заалт хэсэгт заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон болон урьдчилан ирүүлсэн саналыг тоолж, санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн тамга шинэчлэх тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай санал хураалтад 294,516,902 ширхэг буюу 81.63 хувийг эзэмшиж байгаа хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноос:

1.1. Нэр дэвшигч Ч.Ганзориг 294,513,774 ширхэг 99.99% зөвшөөрсөн, татгалзсан байхгүй, түдгэлзсэн байхгүй.

1.2. Нэр дэвшигч Х.Билгүүн 294,381,589 ширхэг 99.95% зөвшөөрсөн, татгалзсан байхгүй, түдгэлзсэн байхгүй.

1.3. Нэр дэвшигч М.Мөнх-Эрдэнэ 294,207,653 ширхэг 99.89% зөвшөөрсөн, татгалзсан байхгүй, түдгэлзсэн байхгүй.

1.4. Нэр дэвшигч О.Одбаяр 294,441,341 ширхэг 99.97% зөвшөөрсөн, татгалзсан байхгүй, түдгэлзсэн байхгүй.

1.5. Нэр дэвшигч Г.Уянга 294,409,693 ширхэг 99.96% зөвшөөрсөн, татгалзсан байхгүй, түдгэлзсэн байхгүй.

1.6. Нэр дэвшигч Г.Сүхбаатар 294,354,692 ширхэг 99.94% зөвшөөрсөн, татгалзсан байхгүй, түдгэлзсэн байхгүй.

1.7. Нэр дэвшигч В.Ганзориг 294,360,918 ширхэг 99.95% зөвшөөрсөн, татгалзсан байхгүй, түдгэлзсэн байхгүй.

1.8. Нэр дэвшигч Б.Солонго 294,207,839 ширхэг 99.9% зөвшөөрсөн, татгалзсан байхгүй, түдгэлзсэн байхгүй.

1.9. Нэр дэвшигч С.Энхчимэг 294,176,737 ширхэг 99.88% зөвшөөрсөн, татгалзсан байхгүй, түдгэлзсэн байхгүй.

1.10 Нэр дэвшигч Т.Булган 354,690 ширхэг 0.12% зөвшөөрсөн, татгалзсан байхгүй, түдгэлзсэн байхгүй.

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх заалтыг үндэслэн 1.1-1.9 дэх хэсэгт заасан нэр дэвшигчид нь ТУЗ-ийн гишүүдээр сонгогдож шийдвэр хүчинтэй.

Хурлын дэгийн дагуу Ард Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийг танилцуулж, энэхүү хурлын хаана уу хэмээн Ард Кредит ББСБ ХК-ийн ТУЗ-ийн дарга Ч.Ганзориг танийг энэхүү тайзан дээр урьж байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр.

Хурлын дарга Ч.Ганзориг:

Тогтоол 1. 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан батлах тухай



Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь заалт, 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 2 тоот тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Ард Кредит ББСБ” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 2026/10 тогтоолоор гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрч баталсугай.

Тогтоол 2. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол улсын компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь заалт болон 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 3 тоот тогтоолыг дүнг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн Компанийн дүрмийн 1.4 дэх заалтыг "Компани нь Хүчтэй.Хамтдаа. гэсэн уриа үгтэй байх бөгөөд компанийн бэлгэдэл тэмдэг нь **Ard** Кредит ББСБ байх ба АРД гэсэн үсгээс бүрдсэн байх ба хажууд нь Кредит ББСБ гэж бичсэн байна." гэж өөрчилсүгэй..
2. Энэхүү шийдвэрийн 1 дэх хэсэгт заасан нэмэлт, өөрчлөлт оруулсан Компанийн дүрмийг хавсралтаар баталсугай.
3. Энэхүү шийдвэрийн хавсралтаар баталсан Компанийн дүрмийг хууль, тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, холбогдох бусад байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар)-т даалгасугай.

Тогтоол 3. Компанийн тамга шинэчлэх тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь хэсэг, , 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 4 тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн брэнд төрх шинэчлэгдэж, компанийн лого өөрчлөгдсөнтэй холбогдуулан одоо ашиглагдаж буй тамгыг хураалгаж, тамганы хяналтын дугаар шинээр авахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангуулж холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар)-д даалгасугай.

Тогтоол 4. ТУЗ-ийн 2026 оны төсөв тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь заалт, 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 5 тоот тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсвийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад даалгасугай.

Тогтоол 5.ТУЗ-ийн гишүүд сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.1, 77.2 дахь заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалт, 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 6 тоот тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

3. Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр дараах нэр дэвшигчдийг сонгосугай.

3.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн Ердийн гишүүд:

- 3.1.1. Хүрэлбаатарын Билгүүн;
- 3.1.2. Чулууны Ганзориг;
- 3.1.3. Мөнхбатын Мөнх-Эрдэнэ;
- 3.1.4. Одончимэдийн Одбаяр;
- 3.1.5. Галнямын Уянга;
- 3.1.6. Гүррагчаагийн Сүхбаатар;

3.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүд:



КРЕДИТ
ББСБ

- 3.2.1. Ванчигийн Ганзориг;
 - 3.2.2. Батсүрэнгийн Солонго;
 - 3.2.3. Сүхбаатарын Энхчимэг;
4. Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа 3 (гурав) жилийн хугацаатай бөгөөд ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрөөр дуусгавар болохыг дурдсугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлж, зохих зөвшөөрлийг авч ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга (Г.Есү-Үжин)-д даалгасугай.

Өнөөдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурал өндөрлөж, хурлыг хааж байна. Ирэх жилийн хурлаараа уулзацгаая. Идэвхитэй оролцсон Хувьцаа эзэмшигч та бүхэндээ баярлалаа.

Хурал хаасан цаг: 12:35.

ХУРЛЫН ДАРГА:
Ч.ГАНЗОРИГ

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
Г.ЕСҮ-ҮЖИН

